

Android үйлдлийн систем бүхий гар утас, таблет төхөөрөмжид IP76 үйлчилгээг ашиглах заавар

VoIP технологид тулгуурласан IP76 үйлчилгээ гэж юу вэ?

Хялбар хэрэглээ, хямд үнэ, хаана ч ашиглах боломжтой суурин утасны дэвшилтэт үйлчилгээ IP76 нь танд Дуут шуудан, Follow me зэрэг дэвшилтэт нэмэлт үйлчилгээнээс гадна онлайнаар хэрэглээгээ хянах, төлбөр төлөх, нэмэлт үйлчилгээний тохиргоо хийх гэх мэт олон давуу талыг олгох болно. Мөн та өөрийн IP76 дугаараа хаана ч ашиглах боломжтой бөгөөд iOS, Android зэрэг хамгийн сүүлийн үеийн үйлдлийн системд зориулсан тусгай програмын тусламжтайгаар гар утас, таблет зэрэг хөдөлгөөнт төхөөрөмж дээрээ ашиглах боломжтой.

ДАВУУ ТАЛ

ХЯЛБАР ХЭРЭГЛЭЭ

IP буюу интернэтээр дамжин дуудлага хийх нь уламжлалт суурин утас ашиглахтай л адил хялбар. Та өөрийн ухаалаг утас, таблет дээрээ зориулалтын апп-г татан авч энэхүү зааврын дагуу тохиргоог хийснээр хаанаас ч, хамгийн хямдаар холбогдох утастай боллоо гэсэн үг. Ямар ч компьютер шаардлагагүй. Тэр ч байтугай хэдэн ч төхөөрөмж дээр зэрэг ашиглах боломжтой.

ХААНА Ч АШИГЛАХ БОЛОМЖ

Ямар нэг тусгай телефон кабелиар холбогддоггүй учир та энэхүү үйлчилгээг хаана ч ашиглах боломжтой. Хэрэв танайх нүүх бол та утсаа шинэ байрандаа интернэтэд холбоход л хангалттай. Зөвхөн нүүхэд ч биш та гадаад амралтаараа аялаж байхдаа ч интернэтэд холбогдсон бүх газраас яг л гэртээ байгаа юм шиг гэрийнхээ дугаараас дуудлага хийх, хүлээж авах боломжтой. Улаанбаатар дах гэр, Тайланд эсвэл Герман дах зочид буудал хаана ч нэг дугаар гэсэн үг.

ХЯМД ҮНЭ

Мэдээж IP76 суурин утас ашигласнаар таны хамгийн түрүүнд мэдрэх зүйл нь хэмнэлт. 76-аар эхэлсэн дугаар бүхий өөрийн сүлжээнд 5₮/мин, Скайтелийн сүлжээнд 30₮/мин, бусад сүлжээнд ердөө 30₮-50₮-р холбогдох боломжтой. Уг үйлчилгээг ашиглахын тулд танд тогтвортой хурд бүхий интернэтийн холболт байхад л хангалттай.


ҮЙЛЧИЛГЭЭГ АШИГЛАХ

Үйлчилгээг ашиглахын тулд дараах шаардлагыг хангасан байх:


- IP76 үйлчилгээний шинэ дугаар худалдан авах. Шинэ дугаарыг ip.skymedia.mn сайтаас авах боломжтой.
- iOS, Android үйлдлийн систем бүхий ухаалаг утас, таблет эсвэл компьютертай байх.
- Интернэтийн тогтвортой хурд бүхий холболт

Доор Андроид үйлдлийн систем бүхий төхөөрөмжид хэрхэн ашиглах зааврыг орууллаа.

Зориулалтын апп-г татаж авах




Google PLAY-с SIP Droid гэж хайн, хайлтын үр дүнд гарч ирсэн Sipdroid апп-г сонгон “Install” товчийг даран суулгана.




Дараагийн алхам: Sipdroid программыг ачаалж хэрэглэгчийн тохиргоог доорх дарааллын дагуу хийнэ үү.


1. Sipdroid программыг ачаална.




2. Settings хэсэгт нэвтрэн Хэрэглэгчийн тохиргоог оруулах шаардлагатай.




3. Хэрэглэгчийн тохиргоог хийхийн тулд SIP Account /Line 1 цэсийг сонгоно.




4. Authorization Username буюу хэрэглэгчийн нэр хэсэгт өөрийн IP76 утасны дугаарыг оруулна.







5. Password буюу нууц үг хэсэгт уг дугаарынхаа PIN кодыг оруулна. PIN кодыг системээс автоматаар олгодог тул та дугаар шинээр үүсгэхдээ уг дугаарыг бичиж авах шаардлагатай. Уг дугаар нь он-лайн дансанд нэвтрэх, дугаарыг ашиглах зэрэгт хамгийн чухал хэрэгцээт мэдээлэл юм.




6. Server or Proxy хэсэгт ip.skytel.mn гэсэн мэдээллийг оруулснаар хэрэглэгчийн тохиргоо хийх үйлдэл дуусна.



7. Хэрэв та үүрэн холбооны 3G холболтыг ашиглан IP76 үйлчилгээг ашиглах бол Use 3G талбарыг идэвхжүүлнэ үү.




8. Таны IP76 дугаараа ашиглан дуудлага хийх, дуудлага хүлээн авах боломжтой болсныг дэлгэцийн дээд талын ногоон гэрэл ассанаар харуулна.



9. Залгах дугаараа цуглуулан дуудлага хийнэ үү. Танд амжилт хүсье.





Санамж:

IP76 үйлчилгээний дугаарын данс цэнэглэх, хэрэглээгээ хянах, нэмэлт үйлчилгээ, Дуут шуудан, Follow me үйлчилгээг идэвхжүүлэх, тохируулахын тулд ip.skymedia.mn сайтанд хандана уу.